



ДОРНОГОВЬ АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 12/04

Сайншанд сум

Орон нутгийн 2022 оны төсвийн  
гүйцэтгэлийг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн орлогыг 76,427.5 сая төгрөгөөр, зарлагыг 86,074.4 сая төгрөгөөр тус тус баталсугай.

2.Орон нутгийн төсвийн гүйцэтгэлд өгсөн аудитын дүгнэлт, зөвлөмж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 70 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Батсугир) нарт тус тус даалгасугай.



ДАРГА

Б.ГАНЗОРИГ

... 442230057